



/СБ аймгийн ЗД-ын 2017 оны А/18 дугаар захирамжаар хүчингүй болгосон/

СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2008 оны 2 дугаар

сарын 27-ны өдөр
Баруун-Урт

Дугаар 85

АЙМГИЙН ШИГШЭЭ БАГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль"-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "а" заалт, "Биеийн тамир спортын тухай хууль"-ийн 18 дугаар зүйлийн 18.8, 18.9, 18.10, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 2.3.13 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Жу-до бөх, сагсан бөмбөг, волейбол, дугуйн спортын төрлөөр аймгийн өсвөр үеийн шигшээ баг байгуулсугай.

Хоёр: Аймгийн шигшээ багийн ажиллах журмыг нэгдүгээр хавсралтаар, шаардагдах хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Гурав. Шигшээ багийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, тайланг жил бүрийн 12 дугаар сарын 25-нд Биеийн тамир спортын хороо, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого зохицуулалтын хэлтэст хүргүүлж байхыг Биеийн тамир спортын хорооны дарга /Ш.Энх-Амар/-д үүрэг болгосугай.

Дөрөв. Шигшээ багийн үйл ажиллагаанд зарцуулагдах 5440000 /Таван сая дөрвөн зуун дөчин мянга/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтэс / Д.Ариунжаргал / -т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Р.ЭРДЭНЭЦОГТ

